



ХЭНТИЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 01 сарын 18 өдөр

Дугаар 8/Н

Хэрлэн сум

Б.Оюундарийг ажилд томилох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.4, 67.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйл, 50 дугаар зүйлийн 50.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 276 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын зэрэглэл”, Засгийн газрын 2022 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 488 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтаар баталсан “Эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээ”, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”-ын 2, 3 дугаар хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Угтах үйлчилгээний ажилтнаар Баатархуягийн Оюундарийг 2023 оны 1 дүгээр сарын 18-ны өдрөөс томилсугай.

2. Б.Оюундарийн сарын үндсэн цалинг ТҮ-6 зэрэглэлээр тогтоон, 766,540 (долоон зуун жаран зургаан мянга таван зуун дөч) төгрөгөөр, ур чадварын нэмэгдлийг 25 хувиар тус тус тооцож олгохыг Нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д зөвшөөрсүгэй.

3. Хөдөлмөрийн гэрээ, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Б.Оюундарьд үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР